

Төрийн албаны зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн
78 дугаар тогтоолын 13 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Эдийн засаг, хөгжлийн яам

Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын Шинжлэх ухааны бодлого, төлөвлөлтийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Шинжлэх ухааны салбарын хүний нөөцийн бодлого, түгээн дэлгэрүүлэлт, Монгол судлалын асуудал хариуцсан шинжээч

Ахлах түшмэл, ТЗ-5

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:


Шинжлэх ухаан, технологийн салбар, инновацын үйл ажиллагааны хүний нөөцийн хөгжил, салбарын нэгдсэн статистик, үндсэн тоон мэдээлэл, суурь болон шалгуур үзүүлэлт, шинжлэх ухаан, технологи, инновацын соёл, түгээн дэлгэрүүлэлт, түүнд хамаарах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлого, төлөвлөлт, хэрэгжилт зохицуулалтыг мэргэжлийн арга зүй, удирдлагаар хангах, холбогдох арга хэмжээг мэргэжлийн түвшинд зохион байгуулж гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Шинжлэх ухаан, технологийн салбар, инновацын үйл ажиллагааны хүний нөөцийг хөгжүүлэх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангах, зохион байгуулах;
- 2.Шинжлэх ухаан, инновац, технологийн салбарын нэгдсэн статистик, үндсэн тоон мэдээлэл, суурь болон шалгуур үзүүлэлт, тэдгээртэй холбоотой эрх зүйн зохицуулалт, бодлого төлөвлөлт, санал, шийдвэрийн төсөл боловсруулах, салбарын нэгдсэн суурь үзүүлэлт, тоон мэдээллийг гаргах, хэрэгжилт, зохицуулалтыг хангах, тайлагнах;
- 3.Шинжлэх ухаан, технологийн салбар, инновацын үйл ажиллагааг сурталчлан, түгээн дэлгэрүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах.
4. Монгол судлалыг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах;
- 5.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, энэ чиглэлд санал, зөвлөмж боловсруулж, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах;	Хүний нөөцийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х
	2.Эрдэмтдийн залгамж халааг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, залуу эрдэмтэд зориулсан тэтгэлэг олгох ажлын хэрэгжилтийг зохион байгуулах;	Тэтгэлэг олгох ажлыг зохион байгуулсан байна.	Г, Х
	3.Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг тогтоох дүрэм журмыг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих;	Эрх зүйн хэм хэмжээг зохицуулсан харилцаа, тэгш байдлыг бүрдүүлсэн байна.	Г, Х
	4.Гадаадад ажиллаж байгаа эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллах санал боловсруулж хэрэгжүүлэх;	Зохион байгуулагдсан арга хэмжээний тоо, санхүүжилт, чанар хүртээмж дээшилсэн байна.	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Шинжлэх ухаан, инновац, технологийн салбарын үндсэн тоон мэдээлэл, суурь үзүүлэлтийг бүрдүүлэх, тэдгээртэй холбоотой	Салбарын үндсэн тоон мэдээлэл, суурь үзүүлэлтийн эрх зүйн	Г, Х, Т

	эрх зүйн зохицуулалт, бодлого төлөвлөлт, санал, шийдвэрийг боловсруулах;	зохицуулалтыг бүрдүүлж, хэрэгжилтийг хангасан байна	
	2.Шинжлэх ухаан, инновац, технологийн салбарын үндсэн тоон мэдээлэл, суурь үзүүлэлтийг боловсронгуй болгох, салбарын нэгдсэн тоон мэдээлэл, суурь үзүүлэлт, мэдээг гаргах, холбогдох хэрэгжилт зохицуулалтыг хангах, суурь үзүүлэлтийг бүхэлд нь хамарсан агуулга бүхий мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, тогтмол шинэчлэх;	Шинжлэх ухаан, инновац, технологийн салбарын суурь үзүүлэлт, тоо, тайлан мэдээ үнэн зөв, бодитой гарах боломжийг бүрдүүлсэн байна.	Г, Х, Т
	3.Салбарын албан ёсны суурь үзүүлэлт, тоон мэдээг олон улсын шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, тогтмол шинэчлэх.	Салбарын албан ёсны суурь үзүүлэлт, тоон мэдээг олон улсын шаардлагад нийцсэн байна.	Г, Х, Т
3 дугаар зорилтын хүрээнд	1.Шинжлэх ухаан, технологийн салбар, инновацын үйл ажиллагааг сурталчлан, түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин /хууль тогтоомж, дүрэм журам, бодлого, хөтөлбөр/-ыг бүрдүүлэх холбогдох дүрэм, журмыг боловсруулж, батлуулах, бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний хэрэгжилт зохицуулалттай холбоотой арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;	Судалгааны ажлууд хийгдэж, салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна. Шинжлэх ухаан, технологийн салбар, инновацын үйл ажиллагааг сурталчлан, түгээн дэлгэрүүлэх ажлууд хийгдэж, хэрэгжилт зохицуулалт бүрэн хангагдсан байна.	Г,Х,Т
	2.Эрдэм шинжилгээний байгууллага, судлаачидтай хамтран судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг олон нийтэд сурталчлан таниулахад чиглэсэн санал боловсруулах, хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, арга хэмжээ зохион байгуулах;	Зохион байгуулсан арга хэмжээ, хүрсэн түвшин дээшилсэн байна.	Г, Т
	3.Шинжлэх ухаан, технологийн салбар, инновацын үйл ажиллагааны гадаад харилцаа(хүний нөөцийн чадавхыг	Хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Г, Х




	бэхжүүлэх, шинжлэх ухаан, технологийн соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлахтай холбоотой)-г өргөжүүлэх санал, гэрээ, хэлцэл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх;		
	4.Үндэсний, салбар, салбар хоорондын болон аймаг, орон нутгийн түвшинд шинжлэх ухаан, технологи, инновацын соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, хөгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Г, Х
	5.Шинжлэх ухаан, технологи, инновацын соёл, түгээн дэлгэрүүлэлттэй холбоотой мэдээллийг салбарын удирдлагын болон нэгдсэн мэдээллийн санд бүртгэж, тогтмол шинэчлэх.	Салбарын удирдлагын болон нэгдсэн мэдээллийн сан бүрдсэн байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Монгол судлалын хөтөлбөр, судалгааны үндсэн чиглэл, суурь судалгааны төслийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;	Эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.	Г, Х
	2.Монгол судлалын чиглэлээр батлагдсан хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах;	Хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжсэн байна.	Г,Х
	3.Гадаад улс орнууд дахь Монгол судлалын төв, эрдэмтэн судлаачидтай хамтарч ажиллах үйл ажиллагааг зохицуулалтаар хангах;	Хамтын ажиллагааг бэхжүүлсэн байдал, хүрсэн түвшин, Гадаад дахь монгол судлалын төвийн тоо, олгосон санхүүжилт, чанар, үр дүн дээшилсэн байна.	Г,Х
	4.Монгол судлалын зөвлөл /орон тооны бус/-ийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт, үйл ажиллагааг зохицуулалтаар ханган ажиллах.	Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х, Т
5 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах,	Хууль тогтоомжийн	Г, Х

	дүгнүүлэх ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх;	хүрээнд ажилласан байна.	
	2. Яамны удирдлага, бусад нэгжээс шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг шуурхай, чанартай, гаргаж өгөх;	Хууль тогтоомжийн хүрээнд ажилласан байна.	Г
	3. Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг “Яамны хөтлөх хэргийн жагсаалт”-ын дагуу архивын нэгж болгон хадгалуулах;	“Яамны хөтлөх хэргийн жагсаалт”-ын дагуу архивын нэгжийг бүрдүүлсэн байна.	Г
	4. Төрийн бус байгууллага иргэдтэй эрхэлсэн ажлын чиглэлээр хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээлэл өгөх.	Хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжилт хангагдсан байна.	Т, Г, Х

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй		
Мэргэжил	- Нано шинжлэх ухаан, инженерчлэл /078801/; - бизнесийн удирдлага /041301/; - эрхзүй /0421/; - хэл шинжлэл /023202/; - нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүлзүй /0321/.		
Мэргэшил	Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж, төгссөн байх.		
Туршлага	- Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-өөс доошгүй жил ажилласан байх; - хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- шинжлэх ухааны салбарын бүтэц, тогтолцоо болон хүний нөөцийн хөгжлийн аливаа асуудлыг оношлох, шалтгааныг тодорхойлох, задлан шинжлэх; - судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх; - шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; - мэдээлэлд тулгуурлан чиг үүргийн болон системийн дүн шинжилгээ хийх; - баримт бичиг боловсруулах (хууль зүйн үндэслэлтэй, асуудлыг бүрэн хамарсан, үг, үсэг, найруулгын болон логикийн хувьд алдаагүй, ойлгомжтой бичих) дүгнэх чадвартай байх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг оновчтой тайлагнах; - бусад.	

	Асуудал шийдвэрлэх	- үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цагийг баримтлан, харилцааны соёлыг эрхэмлэх; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - бүтээлч, санаачлагатай ажиллах, үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх; - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа эерэг мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч нээлттэй харилцааг бий болгох; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгох, хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах; - мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах; - хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх; - бусад.
	Бусад	- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөж, ёс зүйн шаардлагыг биелүүлэх; - ажлын цагийг баримтлан ажиллах; - жендэрийн эрх тэгш байдлын зарчмыг баримтлах; - багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусад таниулах; - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - төрийн албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, монгол бичгийн найруулгын чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах чадвартай байх; - үр дүнтэй, нээлттэй харилцаа бий болгох, эргэх холбоотой ажиллах; - иргэд, үйлчлүүлэгчтэй эелдэг, адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцах; - төрийн үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүйгээр хөнгөн шуурхай хүргэх; - компьютерын хэрэглээний программ, интернэт, и-мэйл зэрэг мэдээлэл харилцааны технологийг бүрэн ашиглах чадвартай байх; - харилцааны соёлыг эрхэмлэн, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх; - бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх;



		- албан ажлын хүрээнд олж авсан мэдээллийг нууцлах; - харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх; - төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах; - эрдэм шинжилгээний байгууллагад ажиллаж байсан бол давуу тал болно.
--	--	--

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Шинжлэх ухааны бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

-байхгүй

Бусад харилцах субъект

- Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс;
- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан;
- Иргэн, хуулийн этгээд мэргэжлийн байгууллага.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

ТУ32861 6806235 9022010236

2025 оны 03 дугаар сарын 24-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын
шийдвэр:

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 25 02 05

Дугаар: 078

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

Шийдвэрийн огноо: 2025.03.24

Дугаар: А/80
(тамга/ тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА: (И.БАТХҮҮ)

2025 оны 03 дугаар сарын 24-ны өдөр